



2023 он 12 сар 13 өдөр

Дугаар 29/23

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн оролцогч талуудтай харилцах
хамтран ажиллах бодлого батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн “Компанийн оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлого”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх Захирал (Г.Цогбадрах)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-г тус тус даалгасугай.

ДАРГА



О.ОДБАЯР

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү баримт бичгээр компанийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг тодорхойлох бөгөөд бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн хувьцаа эзэмшигч, ажилтан, хэрэглэгч үйлчлүүлэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, зохицуулагч, олон нийт, төрийн байгууллагатай хэрхэн харилцах, хамтын ажиллагааг тодорхойлоход оршино.

Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. ТУЗ энэхүү бодлогын баримт бичгийг батлах бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороогоор дамжуулан хяналт тавьж ажиллана.

2.2. Компанийн зүгээс оролцогч талуудад компанийн үйл ажиллагаанд холбогдох мэдээллийг нээлттэй, ил тод хэлбэрээр хүргүүлэх, оролцогч талуудаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, тэдгээрийн дагуу тодорхой ажил зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд компанийн эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулан хариу өгөх үйл ажиллагааг зохион байгуулах замаар бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3. Компанийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ашиглана.

2.4. Энэхүү бодлогын хүрээнд компанийн үйл ажиллагаа, оролцогч талуудтай харилцах харилцаанд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхийг зорино.

2.5. Бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхийг эрмэлзэнэ. Үүнд:

2.5.1 Оролцогч талуудын эрх ашигт хүндэтгэлтэй хандаж, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх, харилцааны зөв хэв маягийг хэвшүүлэх, цаашдын хамтын ажиллагааг тодорхойлох;

2.5.2 Оролцогч талуудыг цаг хугацаанд нь үнэн зөв, бодит мэдээллээр хангах;

2.5.3 Хөрөнгө оруулагчидтай харилцах сайн засаглалд нийцсэн мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, компанийн үнэ цэн болон засаглалыг сайжруулах.

Гурав. Оролцогч талууд

3.1. Хувьцаа эзэмшигчийг компанийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэгч гэдэг утгаар нь түүний хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн тэгш хандаж, компанийн талаар мэдээлэл авах болон бусад эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг Гүйцэтгэх удирдлага бүрдүүлнэ.

3.2. Ажилтныг компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэдэг утгаар нь түүнтэй харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд харилцана.

3.2.1. хөдөлмөрийн дотоод журамд ажилтны эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх зохицуулалтыг тусгах ба хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй байх;

3.2.2. ажилтны гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ ажилтанд ашигтай байдлаар шийдэх.

3.3. Даатгуулагч, харилцагчийг компанийн орлогыг бүрдүүлэгч гэсэн утгаар нь тэдний хэрэгцээг чанар, тоон үзүүлэлтээр бүрэн хангах зорилго бүхий байгууллагын соёлыг бүрдүүлж ажиллана.

3.4. Даатгуулагч, харилцагчтай харилцах харилцаанд гарсан зөрчил, маргааныг эв дүйгээр тохиролцож, харилцан буулт хийх замаар шийдэх.

3.5. Даатгуулагч, харилцагчтай харилцах харилцаанд гарсан зөрчил, маргааныг эв дүйгээр тохиролцож, харилцан буулт хийх замаар шийдэх, харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлэх.

3.6. Зохицуулагч байгууллага, төрийн байгууллагад хүргүүлэх тайлан мэдээг холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангасан хэлбэрээр, цаг тухайд нь хүргүүлнэ.

3.6.1. зохицуулагч, төрийн байгууллагатай харилцах харилцаанд цахим хэрэгслийг түлхүү ашиглах

3.6.2. хууль тогтоомж зөрчсөн аливаа үйлдэл гаргахгүй байх.

3.7 Санал, хүсэлт хүлээн авах.

3.7.1 Ард даатгал ХК-ийн албан ёсны цахим хаяг info@arddaatgal.mn;

3.7.2 Ард даатгал ХК-ийн 77200088 дугаарын утсаар;

3.7.3 Компанид өөрийн биеэр ирэн цаасаар санал хүсэлтээ өгөх;

3.8 Оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг оффис менежер нэгдсэн бүртгэлд бүртгэн Хүний нөөцийн менежер, холбогдох даатгалын болон нөхөн төлбөрийн менежерт шилжүүлэх бөгөөд ажлын 7 хоногийн дотор холбогдох хариуг өгнө.

Дөрөв. Бусад

4.1 ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.